

**СҮХБААТАР ДҮҮРГИЙН ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ АЛБАНЫ  
2024 ОНЫ 06 ДУГААР САРЫН  
БАРАА, АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭ ХУДАЛДАН АВАЛТЫН ТУХАЙ ТАЙЛАН**

2024.07.03

**НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ**

Сүхбаатар дүүргийн Засаг даргын дэргэдэх Худалдан авах ажиллагааны алба нь дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн 11/67 дугаар тогтоолоор батлагдсан дүүргийн төсвийн хөрөнгөөр хэрэгжих хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний төлөвлөгөөг хүлээн авч, худалдан авах ажиллагааг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, холбогдох журам зааварт нийцүүлэн зохион байгуулан ажиллалаа.

**1.1. Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2024 оны 6 дугаар сарын худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний биелэлтийг санхүүжилтийн эх үүсвэр тус бүрээр тоо баримт, биелэлтийн хувийн хамт ерөнхий байдлаар дүгнэн бичнэ.**

**2024 оны 6 дугаар сарын худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний биелэлт:**

*а. Дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих бараа, ажил, үйлчилгээ худалдан авалт:*

Дүүргийн ИТХ-аас дүүргийн төсвийн хөрөнгөөр нийт 85,764.4 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр батлагдсан бөгөөд Захиалагчаас захиалгын хуудсын дагуу зарим төсөл арга хэмжээ багцад хуваагдаж батлагдсантай холбоотойгоор төсөл арга хэмжээний тоо нэмэгдэж 101 төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг хэрэгжүүлэхээр төлөвлөгөөнд өөрчлөлт орсон. 2024 оны 06 дугаар сарын 17-ны өдөр төлөвлөгөөнд нэмэлт өөрчлөлт орж 88,764.4 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 102 төсөл арга хэмжээ болж өөрчлөгдсөн.

Худалдан авах ажиллагааны хэрэгжилт дараах байдалтай байна. Үүнд:

№	Худалдан авах ажиллагааны зохион байгуулалт	Төсөвт өртөг (сая. Төг)	Төсөл арга хэмжээний тоо
1	Худалдан авах ажиллагааг бүрэн хэрэгжүүлсэн	37516.4	68
2	Тендерийн шатанд, дахин зарласан	5081.5	8
3	Дахин зарлах	2200.6	9
4	Үнэлгээний шатанд	700.0	2
5	Захиалга ирээгүй үнэлгээний хороо байгуулагдсан	13412.8	4
6	Захиалга ирээгүй үнэлгээний хороо байгуулагдаагүй	24853.4	8
7	Гомдол гарсан	3720.9	2
8	Цуцалсан	1278.9	1
<b>ДҮН</b>		<b>88764.5</b>	<b>102</b>

Төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилт 2024 оны 6 дугаар сарын байдлаар 87.3 хувийн гүйцэтгэлтэй байна.

Худалдан авах ажиллагааг хуулийн хүрээнд хэрэгжүүлснээр 1208.8 сая төгрөгийн төсвийн хэмнэлт үүсгэн ажиллалаа.

*б. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжих бараа, ажил, үйлчилгээ худалдан авалт:*

Дүүргийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2024 онд хэрэгжих 1690.8 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 7 төсөл арга хэмжээ батлагдсан.

Худалдан авах ажиллагааны хэрэгжилт дараах байдалтай байна. Үүнд:

№	Худалдан авах ажиллагааны зохион байгуулалт	Төсөвт өртөг (сая. Төг)	Төсөл арга хэмжээний тоо
1	Худалдан авах ажиллагааг бүрэн хэрэгжүүлсэн	1690.8	7
<b>ДҮН</b>		<b>1690.8</b>	<b>7</b>

Төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилт 2024 оны 6 дугаар сарын байдлаар 100 хувийн гүйцэтгэлтэй байна.

Худалдан авах ажиллагааг хуулийн хүрээнд хэрэгжүүлсэнээр 39.8 сая төгрөгийн төсвийн хэмнэлт үүсгэн ажиллалаа.

*в. Улс, нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих /худалдан авах ажиллагааны эрх шилжин ирсэн/ бараа, ажил, үйлчилгээ худалдан авалт:*

Нийслэлийн Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн А/1489 дүгээр захирамжаар нийслэлийн Төсвийн хөрөнгөөр 2024 онд хэрэгжих 400.0 сая төгрөг бүхий 3 багцтай төсөл арга хэмжээний эрх шилжиж ирсэн.

Худалдан авах ажиллагааны хэрэгжилт дараах байдалтай байна. Үүнд:

№	Худалдан авах ажиллагааны зохион байгуулалт	Төсөвт өртөг (сая. төг)	Төсөл арга хэмжээний тоо
1	Худалдан авах ажиллагааг бүрэн хэрэгжүүлсэн	400.0	3
<b>ДҮН</b>		<b>400.0</b>	<b>3</b>

Төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилт 2024 оны 6 дугаар сарын байдлаар 100 хувийн гүйцэтгэлтэй байна.

Худалдан авах ажиллагааг хуулийн хүрээнд хэрэгжүүлсэнээр 44.2 сая төгрөгийн төсвийн хэмнэлт үүсгэн ажиллалаа.

*г. Дүүргийн төсвийн бусад эх үүсвэрээр хэрэгжих бараа, ажил, үйлчилгээ худалдан авалт:*

Дүүргийн Засаг даргын захирамжаар дүүргийн төсвийн бусад эх үүсвэрийн хөрөнгөөр санхүүжих тухайн цаг үеийн шинж чанартай худалдан авалтыг зохион байгуулахаар 2024

оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд 2660.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 8 төсөл арга хэмжээ тусгагдсан. 2024 оны 03 дугаар сарын 12-ны өдөр, 04 дүгээр сарын 05-ны өдөр, мөн 2024 оны 05 дугаар сарын 20-ны өдөр, 2024 оны 06 дугаар сарын 17-ны өдөр тус тус төлөвлөгөөнд нэмэлт өөрчлөлт орж 21216.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 56 төсөл арга хэмжээ болж өөрчлөгдсөн.

Худалдан авах ажиллагааны хэрэгжилт дараах байдалтай байна. Үүнд:

№	Худалдан авах ажиллагааны зохион байгуулалт	Төсөвт өртөг (сая. Төг)	Төсөл арга хэмжээний тоо
1	Худалдан авах ажиллагааг бүрэн хэрэгжүүлсэн	6052.6	21
2	Тендер зарлагдсан шатанд	304.1	7
3	Тендерийн баримт бичиг боловсруулж байгаа	348.0	1
4	Дахин зарлах	432.3	2
5	Үнэлгээний шатанд	400.0	1
6	Захиалагчид төсөв хянуулахаар буцаасан	723.0	5
7	Гомдол гарсан	96.0	1
8	Захиалга ирээгүй, үнэлгээний хороо байгуулагдсан	8850.0	7
9	Захиалга ирээгүй, үнэлгээний хороо байгуулагдаагүй	4010.0	11
<b>ДҮН</b>		<b>21216.0</b>	<b>56</b>

Төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилт 2024 оны 6 дугаар сарын байдлаар 67.9 хувийн гүйцэтгэлтэй байна.

Худалдан авах ажиллагааг хуулийн хүрээнд хэрэгжүүлсэнээр 267.5 сая төгрөгийн төсвийн хэмнэлт үүсгэн ажиллалаа.

Төсвийн хөрөнгө оруулалтын худалдан авах ажиллагааны зохион байгуулалт түүний хэрэгжилт

Төлөвлөгдсөн хөрөнгө оруулалтын хүрээнд нийт 42 үнэлгээний хороо Дүүргийн Засаг даргын захирамжаар байгуулагдсан бөгөөд 2024 онд хэрэгжүүлбэл зохих худалдан авах ажиллагааны хэрэгжилт нэгдсэн байдлаар доорх байдалтай байна.

Төлөвлөгдсөн худалдан авах ажиллагааны хэрэгжилт (2024 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар)

№	Худалдан авах ажиллагааны зохион байгуулалт	Төсөвт өртөг (сая.төг)		Төсөл арга хэмжээний тоо	
		Хэрэгжүүлбэл зохих	Бүрэн хэрэгжсэн	Хэрэгжүүлбэл зохих	Бүрэн хэрэгжсэн
1	Дүүргийн төсвийн хөрөнгө оруулалт	88764.5	37516.4	102	68
2	Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалт	1690.8	1690.8	7	7
3	НОНХС, НТХО	400.0	400.0	3	3
4	Бусад эх үүсвэр	21216.0	6052.6	56	21
НИЙТ ДҮН		112071.3	45659.8	168	99
Хэрэгжилт		58.9%			

Худалдан авах ажиллагааг хуулийн хүрээнд зохион байгуулснаар нийт 1560.3 сая төгрөгийн төсвийн хэмнэлт үүсгэн ажиллалаа. Бүрэн хэрэгжсэн төсөл арга хэмжээний гүйцэтгэл 58.9 хувьтай байна.

Худалдан авах ажиллагааг 100 хувь худалдан авах ажиллагааны [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn) цахим системээр зохион байгуулсан бөгөөд тендерийн Үнэлгээний хороодод тус албаны бүх албан хаагчид санамсаргүй байдлаар сонгогдон, нарийн бичгийн даргаар ажиллаж, батлагдсан төлөвлөгөөний дагуу тендер шалгаруулалтыг зохион байгуулж, тендерийн урилга, баримт бичиг болон үр дүнгийн мэдээллийг тухай бүрт цахим системээр дамжуулан ил тод, нээлттэй байршуулж иргэд, олон нийтийг мэдээллээр ханган ажиллаж байна.

Мэдээллийн нээлттэй, ил тод байдлыг хангах хүрээнд:

- Дүүргийн Засаг даргын баталсан Худалдан авах ажиллагааны зохион байгуулалтын 2024 оны жилийн төлөвлөгөөг [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn), дүүргийн ЗДТГ-ын [www.sbd.gov.mn](http://www.sbd.gov.mn), [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn), [www.report.ub.procurement.mn](http://www.report.ub.procurement.mn) цахим хуудсуудад, мөн дүүргийн худалдан авах ажиллагааны албаны мэдээллийн самбарт байршуулан олон нийтэд нээлттэй мэдээллээ.
- 2024 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн байдлаарх хөрөнгө оруулалтын худалдан авах ажиллагааны мэдээ тайланг ил тод мэдээлсэн бөгөөд тендерийн үр дүнгийн талаарх мэдээллийг [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn), [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn), дүүргийн ЗДТГ-ын [www.sbd.gov.mn](http://www.sbd.gov.mn), [www.report-ubprocurement.mn](http://www.report-ubprocurement.mn) цахим хуудсууд болон дүүргийн худалдан авах ажиллагааны албаны мэдээллийн самбарт байршуулан олон нийтэд нээлттэй хүргэн ажиллаа.

### **1.2 Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний биелэгдээгүй болон дутуу биелсэн ажлын шалтгаан, цаашид хэрэгжүүлэхээр төлөвлөж буй үйл ажиллагааны хамт тусгана.**

Худалдан авах ажиллагааны хэрэгжилт, худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний биелэгдээгүй болон дутуу биелсэн талаарх тайлбарыг тухайн хөрөнгийн эх үүсвэр тус бүрээр гаргасан биелэлтийн мэдээллийн дор тус бүрт нь оруулав.

### **1.3 Тендер шалгаруулалтын үнэлгээг тендерийн хүчинтэй байх хугацаанд хийсэн тухай**

2024 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар нийт 99 төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг бүрэн зохион байгуулсан байна. Тус төсөл арга хэмжээний тендер шалгаруулалтын үнэлгээг тендерийн хүчинтэй байх хугацаанд бүрэн хийж захиалагчид үнэлгээний дүгнэлтийг хүргэж ажилласан болно.

### **Худалдан авах ажиллагааны явцад гарсан зөрчил түүнийг хэрхэн засаж залруулсан тухай /тус бүрээр/**

Худалдан авах ажиллагааны зохион байгуулалтын явцад зөрчил гараагүй болно.

### **1.4 Худалдан авах ажиллагааны талаар гарсан гомдол, түүнийг шийдвэрлэсэн байдал**

Худалдан авах ажиллагааны зохион байгуулалтын явцад “Дүүргийн Нэгдсэн эмнэлгийн тоног төхөөрөмж, материаллаг бааз бэхжүүлэх” 5670.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий төсөл арга хэмжээний тендер зарласан шатанд ШӨХТГ-т гомдол гарсан. Үүний улмаас тендер хүлээн авах эцсийн хугацааг 2024 оны 02 дугаар сарын 13-ны өдөр хүртэл сунгасан.

Тус төсөл арга хэмжээний амжилтгүй болсон багцуудын тендер шалгаруулалтыг дахин зарлах шатанд ШӨХТГ-т гомдол гарсан. Үүний улмаас тендер хүлээн авах

эцсийн хугацааг 2024 оны 05 дугаар сарын 17-ны өдөр хүртэл сунгасан ба үнэлгээ хийгдэж 2024 оны 05 дугаар сарын 30-ны өдөр үр дүн гарсан.

Тус төсөл арга хэмжээний 8, 11 дүгээр багцуудад 2024 оны 05 дугаар сарын 30-ны өдөр үр дүн гарсаны дараа оролцогчоос СЯ-д гомдол гаргаж түдгэлзүүлсэн.

“Дүүргийн Нэгдсэн эмнэлгийн хүчилтөрөгчийн системийн угсралт суурилуулалтын ажил” 1278.8 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий төсөл арга хэмжээний тендер зарласан шатанд ШӨХТГ-т гомдол гарч уг төсөл арга хэмжээг цуцалсан.

“Нэгдсэн эмнэлгийн сүлжээний хамгаалалтын төхөөрөмж” нийлүүлэх 96.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, “Нэгдсэн эмнэлгийн серверийн өрөөний тоног төхөөрөмж” нийлүүлэх 97.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 2 төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааны үр дүн 2024 оны 06 дугаар сарын 10-ны өдөр гарсан. Эдгээр ажлын үр дүнд оролцогч компаниас СЯ-д гомдол гаргасан, дахин зарлахаар бэлтгэж байгаа болно.

#### **1.5 Чанар стандартын шаардлага хангасан дотоодын бараа худалдан авсан мөнгөн дүн, нийлүүлэгчийн нэр, гэрээний хэрэгжилтийн талаар тусгах**

Дотоодын бараа бүтээгдэхүүний давуу эрхийн зөрүү тооцох зорилгоор Тендерийн баримт бичиг бүрт албан хүсэлт болон нотлох баримтыг шаардаж байна. 2024 оны 6 дугаар сарын байдлаар дотоодын давуу эрхийн зөрүү тооцсон төсөл арга хэмжээ байхгүй болно.

### **ХОЁР. ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ЦАХИМ СИСТЕМИЙГ АШИГЛАСАН ТАЛААР**

#### **2.1 Худалдан авах ажиллагааны цахим системээр зарласан тендер шалгаруулалтын тоо, хувь болон системийн талаарх дүгнэж ирүүлнэ.**

Тус алба нь 2024 онд нийслэл, дүүргийн төсвийн болон орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтын хөрөнгөөр хэрэгжих нийт 112071.3 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 168 төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулах төлөвлөгөөтэй ажиллаж байгаагаас 45659.8 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 99 төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг цахим тендерийн системээр бүрэн зохион байгуулаад байна. Мөн цахим тендерийн урилга, үр дүн, гүйцэтгэгчийн гэрээний мэдээллийг тухай бүр системд мэдээлж, нийтэд ил тод нээлттэй ажиллалаа.

#### **2.2 Ерөнхий гэрээ байгуулах журмын дагуу цахим дэлгүүрийн ашиглалт болон тухайн жилд худалдан авсан бараа, үйлчилгээний тоо, мөнгөн дүн, гэрээний хэрэгжилтийн талаар ирүүлнэ.**

Захиалагчийн хувьд ерөнхий гэрээгээр хэрэгжих худалдан авалт байгаагүй тул цахим дэлгүүр ашиглаагүй болно.

### **ГУРАВ. ХАРЬЯА БАЙГУУЛЛАГУУДЫН ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР**

**3.1. Тухайн төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллагуудын тоо, тэдгээрийн худалдан авах ажиллагааны хэрэгжилтийн талаар ерөнхий мэдээлэл, худалдан авах ажиллагааг зааварчилгаа, аргачлалаар хангасан байдал болон түүнд хяналт тавьж ажилласан талаар тусгана.**

**3.2. Төсвийн ерөнхийлөн захирагч өөрийн харьяа байгууллагуудын худалдан авах ажиллагааны хэрэгжилтэд үнэлгээ өгсөн тухай зөвлөмж, дүгнэлт болон авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаарх тайланг хавсарган ирүүлнэ.**

Дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтын үр ашгийг дээшлүүлэх, дүүргийн Засаг дарга, түүний Тамгын газрыг худалдан авах ажиллагаатай холбоотой бүх талын мэдээллээр хангах, зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Захиалагч болох дүүргийн Засаг даргын Тамгын газартай тус алба нь байнга хамтран ажиллаж “Худалдан авах ажиллагааны захиалгын маягт”-ын дагуу төсөл арга хэмжээ бүрийн захиалга даалгаврыг хүлээн авч боловсруулан, мэдээ мэдээллийг тухай бүрт нь хүргэн ажиллалаа.

## **ДӨРӨВ. ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААРХ ДҮГНЭЛТ, САНАЛ**

### **4.1. Захиалагчийн тухайн жилийн худалдан авах ажиллагааны хэрэгжилтийн үр дүнгийн талаарх өөрийн үнэлгээ, дүгнэлтийг тодруулан гаргаж тавина.**

2024 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар нийт 99 төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг бүрэн зохион байгуулсны худалдан авах ажиллагааны журмын сонголт дараах байдалтай байна. Үүнд:

- Нээлттэй тендер шалгаруулалтын аргаар 80 төсөл арга хэмжээ;
- Тендер шалгаруулалтын онцгой журмын харьцуулалтын аргаар 18 төсөл арга хэмжээ;
- Шууд худалдан авалт 1 төсөл арга хэмжээ тус тус зохион байгуулсан байна.

2024 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар нийт төлөвлөгдсөн төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг бүрэн зохион байгуулсан буюу 58.9 хувийн гүйцэтгэлтэй байна.

Худалдан авах ажиллагааг хуулийн хүрээнд зохион байгуулснаар нийт 1560.3 сая төгрөгийн төсвийн хэмнэлт үүсгэн ажиллалаа.

### **4.2. Гэрээний хэрэгжилтэнд хяналт тавьж ажилласан тухай**

Гэрээний хэрэгжилтийг захиалагч дүүргийн Засаг даргын Тамгын газраас хяналт тавин ажиллаж байгаа бөгөөд нийслэлийн Засаг даргаас худалдан авах ажиллагааны эрх шилжин ирсэн төсөл арга хэмжээний хэрэгжилтэд нийслэлийн Засаг даргын тамгын газар, Нийслэлийн хөрөнгө оруулалтын газар тус тус хяналт тавьж ажиллаж байна.

СҮХБААТАР ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ  
ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ АЛБА